

УЛААНБААТАР ХОТ
БАТЛАВ
“СҮХБААТАР ДЭВШИЛ” ОНӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.АМГАЛАН

ХӨДӨЛМӨР, ХАМГААЛЛЫН ХУВЦАС ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
2025 оны 06 дугаар сарын 13
Улаанбаатар хот

№	Барааны нэр	Хэмжих нэгж	Техникийн тодорхойлолт
1	2	3	4
1	Ажлын хувцас (Зун)	Хос	Хувцас, хамгаалах хэрэгслийн загварыг байгууллагатай тохирч, загвар хувцас хийж ирүүлж зөвшилцөнө. Хувцасны размерын судалгааг нийлүүлэгч байгууллагын размер авах зааврын дагуу гаргаж өгнө. Ажлын тусгай хувцас хийх материал нь стандартын шаардлага хангасныг нотлох баримттай байх. Баталгаат хугацаатай байх. Баталгаат хугацааны дотор эдэлгээ, размерын ямар нэгэн асуудал гарахад хасах, сольж өгөх бүрэн боломжтой байна.
2	Ажлын хувцас (Өвөл)	Хос	
3	Ажлын комбинзон	Ширхэг	
4	Нэг удаагийн хамгаалалтын хувцас	Ширхэг	
5	Оффисын ажилчдын ажлын хувцас	Ширхэг	

№	Барааны нэр	Хэмжих нэгж	Техникийн тодорхойлолт
1	2	3	4
1	Ажлын хувцас (Зун)	Хос	Тусгай зориулалтын ажлын хувцасны MNS 6231:2011 стандартын шаардлагатай дүйцэхүйц байх. Зуны ажлын хувцасны бүрдэл. Үүнд: Зуны ажлын хувцас нь хүрэм, өмд гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Хүрэм, өмд нь хөх цэнхэр, юнител ногоон, хар саарал тус тус өнгийн цахилгаанждаггүй, галд өртсөн үед хүний биед наалддаггүй, цэвэрлэхэд хялбар, будаг гаргахгүй, стандартын шаардлага хангасан цэвэр даавуугаар хийгдсэн байна. - Ажлын хувцсанд хаяг, размерын дугаар, угаалга, хатаалгын тэмдэг зэрэг мэдээллийг оруулсан шошго стандартын шаардлагын дагуу оёгдсон байна. Хүрэм: Зуны хүрэмд дараах загвар, хийцүүдийг тусгасан байна. Материал: Жинсэн материалтай дүйцэхүйц байх; Оёдол: Хүрэм болон өмд нь гурван давхар өнгө дагуу оёдолтой байна; - Ханцуйны манжетиктай, манжетик нь товчтой; - Хүрэм нь чанартай цахилгаантай, цахилгаан нь далд товчлоостой даравчтай байна. Даравч нь гурван товчтой байна;

1	Ажлын хувцас (Зун)	Хос	▪ Энгэр болон ташаанд даравчтай ил халаастай, даравч нь товчтой байна; ▪ Хүрмийн энгэр болон ташааны хоёр халааснууд том гар утас орох эзлэхүүнтэй халаасны даравч нь товчтой байна; ▪ Ханцуй нь ажил гүйцэтгэх үед хөдөлгөөн дэмжигчтэй, суганы ар хэсгээс мөрний дээд оёдол хүртэл байх; ▪ Энгэр, ар нурууны хэсэгт гэрэл ойдог туузан оруулгатай байх. Хүрмийн ар тал нь захны залгааснаас доош 15 см урд тал нь мөрний залгааснаас энгэрийн халаас хүртэл улбар шар, цэнхэр тус тус өнгийн байна; Өмд: Өмдний загвар хийц дараах шаардлагыг хангасан байна. ▪ Өмд нь өвдөгний хэсэгт давхарлагатай, өвдөгний ар хэсэгт хуниастай байх; ▪ Арын суудлын хэсэгт давхарлагатай; ▪ Өмдний салтаа давхар оруулгатай байх; Хөдөлгөөнд саад учруулахгүй, суудал өндөртэй байх; ▪ Ташааны оёдолд орсон халаастай, сууж ажил гүйцэтгэхэд тохиромжтой байх; ▪ Хажуу талд эзлэхүүнтэй ил халаастай, халаас нь даравч товчтой байх; ▪ Шуумгийн хэсэг шулуун, нарийсах боломжтой татагчтай байх; ▪ Өвдөг хэсэгт давхар оруулгатай байх. Загварт захиалагчийн саналыг тусгаж засварлахыг зөвшөөрсөн байх.
2	Ажлын хувцас (Өвөл)	Хос	-Тусгай зориулалттай ажлын хувцасны MNS 6231:2011 стандартын шаардлагатай дүйцэхүйц байх. Өвлийн ажлын хувцас нь хүрэм өмд гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Хүрэм, өмд нь хөх цэнхэр, юнител ногоон, хар саарал тус тус өнгийн цахилгаанждаггүй, галд өртсөн үед хүний биед наалддаггүй, галд өртсөн үед хүний биед наалддаггүй, цэвэрлэхэд хялбар, будаг гаргахгүй, стандартын шаардлага хангасан цэвэр даавуугаар хийгдсэн байна. ▪ Ажлын хувцсанд хаяг, размеров дугаар, угаалга, хатаалгын тэмдэг зэрэг мэдээллийг оруулсан шошго стандартын шаардлагын дагуу оёгдсон байна. Хүрэм: ▪ Өвлийн хүрэмд дараах загвар, хийцүүдийг тусгасан байна; ▪ Хүрэм нь үндсэн дулаалга болон салдаг дулаалга бүхий дотортой байх; ▪ Салдаг дотор нь дулаалгыг тайлснаар хавар, намрын улиралд өмсөх боломжтой

			байх. Салдаг дотрыг ажлын байранд өмсөх боломжтой байх; ■ хөх цэнхэр, юнител ногоон, хар саарал тус тус өнгийн хослолоор хийгдсэн байх; ■ Салдаг дотрын загварыг захиалагчтай зөвшилцөж гаргах; ■ Зах нь босоо байх; ■ Ханцуйн үзүүр хэсгийн дотор талд салхи орохоос хамгаалах давхар бариу резинэн ханцуйвчтай байх; ■ Бүсэлхийн хэсэгт дотор талдаа салхи орохоос хамгаалсан гүйдэг уяатай бүстэй байх; ■ Далд товчлоостой байх; ■ Энгэрийн дээд хэсэгтээ тагтай халаастай, ташаан хэсэгт эзлэхүүнтэй ил халаастай байх; ■ Энгэр, ар нурууны хэсэгт гэрэл ойдог туузан оруулгатай байх. Өмд: Өмдний загвар хийц дараах шаардлагыг хангасан байна. ■ Нуруугаар салхи орохоос хамгаалах өндөр оруулгатай, бүсэлхийгээрээ сунаж агших чөлөөтэй өмсөж тайлах байдлыг хангасан резинэн оруулга бүхий хуниастай, сууж ажил гүйцэтгэхэд тохиромжтой байхаар хийгдсэн байх; ■ Өмд нь дотроо дулаалга бүхий хэсэгтэй байх; ■ Угааж цэвэрлэх үед хэлбэр хэмжээ, дулаан алдагдал багасахгүй байх; ■ Өвдөгний хэсэгт давхарлагатай байх; ■ Арын суудлын хэсэгт давхарлагатай байх; ■ Ташааны хэсэгт оёдолд орсон эзлэхүүнтэй халаастай байх; ■ Өвдөгний хажууд эзлэхүүн бүхий даравчтай ил халаастай, даравч нь товчтой байх; ■ Шуумгийг зангуу товчоор нарийсгах боломжтой байх; ■ Шуумгийн дотор талд салхи орохоос хамгаалах давхар бариу резинэн шуумагтай байх; ■ Бүх хэсэг нь 3-н давхар оёдолтой, өнгө дагуу утсаар оёгдсон байх; Загварт захиалагчийн саналыг тусгаж засварлахыг зөвшөөрсөн байх.
3	Ажлын комбинзон	Ширхэг	Тусгай зориулалтын ажлын хувцасны MNS 6231:2011 стандарттай дүйцэхүйц байх. Ажлын комбинзон нь хар саарал өнгийн цахилгаанждаггүй, галд өртсөн үед хүний биед наалддаггүй, цэвэрлэхэд хялбар, будаг гаргахгүй, стандартын шаардлага хангасан цэвэр даавуугаар хийгдсэн байна. Ажлын хувцсанд хаяг, размерын дугаар, угаалга, хатаалгын тэмдэг зэрэг мэдээллийг

			оруулсан шошго стандартын шаардлагын дагуу оёгдсон байна. ▪ Материал: Жинсэн материалтай дүйцэхүйц байх; ▪ Сайн чанарын материалаар хийгдсэн байх; ▪ Энгэр, ар нурууны хэсэгт гэрэл ойдог туузан оруулгатай байх; ▪ Оёдол: Комбинзон нь гурван давхар өнгө дагуу оёдолтой байна; ▪ Ханцуйны Ханцуйны манжетиктай, манжетик нь сунадаг, хар өнгөтэй байх; ▪ Комбинзон нь чанартай цахилгаантай, цахилгаан нь далд товчлоостой даравчтай байна. ▪ Өмсөж тайлахад хүндрэлгүй байх; хөнгөн хүндээр бие засах үед хүндрэлгүй цахилгаантай байх ▪ Ар нурууны хэсэгт хөдөлгөөн дэмжигч хуниастай байх; ▪ Хоёр халаастай, өвдөгний хажууд ил хоёр халаастай, халаас нь гар утас багтах эзэлэхүүнтэй, даравчтай товчтой байх ▪ Комбинзоны тохой, өвдөг, өгзөг хэсэгт давхар оруулгатай байх ▪ Захиалагчтай ажлын комбинзоны материал загварыг урьдчилан тохирно; Урьдчилан тохирсон загвараар нэг туршилтын дээж захиалагчид ирүүлэн баталгаажуулсны дараа батлагдсан загварын ажлын комбинзоны нийлүүлэлтийг хийнэ.
4	Нэг удаагийн хамгаалалтын хувцас	Ширхэг	Нэг удаагийн хамгаалалтын хувцас нь MNS6853:2020 стандартын шаардлагатай дүйцэхүйц байх. ▪ Комбинезоны ерөнхий бүтэц нь бүтэн биеийг халхавчилсан байх; ▪ Комбинезоны бүрдэл хэсгийн залгаасыг дарсан наалтыг үрчлээгүй жигд наасан байна; ▪ Ажлын хувцасны гадуур өмсөх зориулалттай байх; ▪ Биед эвтэйхэн, хөнгөн, гар хөл, толгойны хөдөлгөөнийг хязгаарлахааргүй байна; ▪ Бүрдэл хэсгүүдийн хавсрах оёдлыг хэрээсэлж оёсон байх; ▪ Сунадаг юүдэнтэй байх; ▪ Цахилгаан товч нь далдлагддаг байх; ▪ Толгой, бүсэлхий, ханцуй, шагайн хэсгээр уян сунамтгай байх; ▪ Хөвөн, утасны хог үүсгэхгүй байх Урьдчилан тохирсон загвараар нэг туршилтын дээжийг хийж захиалагчид ирүүлэн баталгаажуулсны дараа батлагдсан загвараар нэг удаагийн хамгаалалтын хувцсыг хийнэ
5	Оффисын ажилчдын ажлын хувцас	Ширхэг	Тусгай зориулалттай ажлын хувцасны MNS 6231:2011 стандартын шаардлагатай дүйцэхүйц байх.

			▪ Зуны ажлын захгүй богино хүрэм байх; ▪ Өнгө үзэмжтэй, хөнгөн, өмсөхөд биед эвтэйхэн байна; ▪ Хүрмийн урт нь нуруу ил гарахааргүй ташаа дарсан байна; ▪ Өнгө: хөх өнгөтэй байна; ▪ Материал: Куртканы зориулалтын материалтай дүйцэхүйц байх ▪ Хүрэм нь чанартай цахилгаантай бат бөх байх угаахад тэсвэртэй материалаар хийгдсэн байх; ▪ Өнгө ба дотор материал нь угаахад агшдаггүй, будаг гардаггүй, дулаан алдахгүй, оёдол даах чадвартай байна; ▪ Оёдол: Ханцуйны манжетиктай, манжетик нь сунадаг, хар өнгөтэй байх; ▪ Хүрмийн ташааны хоёр халаас нь том гар утас орох эзлэхүүнтэй халаасны даравч нь товчтой байна; ▪ Хүрмийн дотор талд цахилгаан халаастай байх; ▪ Залгаас болгоныг бат бөх байлгах үүднээс давхар оёдол хийсэн байх; ▪ Захиалагчтай ажлын хувцасны материал, загварыг урьдчилан тохирно. Урьдчилан тохирсон загвараар нэг туршилтын дээжийг хийж захиалагчид ирүүлэн баталгаажуулсны дараа батлагдсан загвараар ажлын хувцсыг хийнэ.
--	--	--	--

Захиргаа, санхүүгийн алба